



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/47

Дэлгэрхаан сум

**Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/125 дугаар тушаал, Хэнтий аймгийн Мал эмнэлгийн газрын даргын А/26 тушаал, Хэнтий аймгийн Засаг даргын А/234 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад сумын бүх үхэр болон отрын бүс нутгийн үхэрт 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн 28 хоногт багтаан зохион байгуулж ажиллахыг "Батмэнд сүрэг", "Цагаантан- Эрдэнэ", "Баянхааны сүрэг" мал эмнэлгийн аж ахуйн нэгжүүдийн захирал, малын эмч Ч.Хоролмаа, Ц.Хүрэлбаатар, С.Сарантуяа, О.Батболд нарт даалгасугай.

2.Багийн малчдад урьдчилан мэдэгдэж зар хүргэх, малчдын малыг бэлэн байлгах, тарилгын хашаа хоолойг малчдаар бэлтгүүлэх,малчид, мал бүхий иргэдийг татан оролцуулж, хүн хүч, тээврийн хэрэгслээр хангаж ажиллахыг багийн Засаг дарга Б.Энхцэцэг, Н.Цэнддолжин, Б.Мөнхболд, Д.Оюунчимэг, Г.Батнасан нарт, шаардагдах вакцин эм бэлдмэлийг татан авч, мал эмнэлгийн аж ахуй нэгжүүдэд хуваарилах, мэргэжил арга зүйгээр хангаж, тарилгын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, мал эмнэлгийн арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бий болгосон иргэд, албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцох, тарилгын материалыг хугацаанд нь хүргэж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Д.Баярмаа)-д үүрэг болгосугай.

3.Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын чанар, явц, гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавьж ажиллахыг сумын онцгой комиссын гишүүд, мэргэжилтэн нарын хуваарийг хавсралтаар баталсугай.


4.Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Батнасан)-д хариуцуулсугай.

ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН



Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 28
өдрийн 11/47 дугаар захирамжийн хавсралт



ШҮЛХИЙ ӨВЧНИЙ ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖИЛД ХЯНАЛТ ТАВЬЖ ХАРИУЦАН
АЖИЛЛАХ ХУВААРЬ

д/д	Сумын нэр хариуцсан албан хаагч	Баг	Багийн нэр	Албан тушаалтны нэр	Утасны дугаар
1	Сумын засаг даргын орлогч Д.Батнасан	1	Хэрлэнбаян- Улаан	Б.Энхцэцэг	96019047
2	Сумын засаг даргын орлогч Д.Батнасан	2	Долоод	Н.Цэнддолжин	89640831
3	Сумын засаг даргын орлогч Д.Батнасан	2	Долоод	Х.Мөнхбат	98977657
4	Сумын засаг даргын орлогч Д.Батнасан	3	Аварга	Б.Мөнхболд	88035385
5	Сумын засаг даргын орлогч Д.Батнасан	4	Хэрлэн тооно	Д.Оюунчимэг	99515381
6	Сумын засаг даргын орлогч Д.Батнасан	4	Хэрлэн тооно	У.Ариунтуяа	96057779
7	Сумын засаг даргын орлогч Д.Батнасан	5	Баянхаан	Г.Батнасан	88173421
8	Сумын засаг даргын орлогч Б.Баттулга	5	Баянхаан	Д.Баярмаа	88768960

